



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АЙМГИЙН 2021-2025 ОНЫ ТАВАН
ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ,
САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ОЛГООГҮЙ БАЙНА.

ТАЙЛАН
БЭЛТГЭСЭН:

Аудитын тайлангай
холбоотой нэмэлт
мэдээллийг
[www.open.audit.mn](#)
хаягаас үзнэ үү

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх
аудитор

Д.Бат-Ундраа

Утас: 7046-3612, bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер

Х.Болдбаатар

Утас: 7046-3783, boldbaatar@audit.gov.mn

Аудитор

Б.Мөнхнасан

Утас: 90066888, munkhnasanb@audit.gov.mn

Н.Цогтсайхан

tsogtsaikhann@audit.gov.mn

О.Алтансүвд

altansuvd.oyu@audit.gov.mn

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан
бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын
баталсан Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2026
оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн аудитыг хийж
гүйцэтгэсэн.

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт,
зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан
тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг
зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ.
Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх
төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний
худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион
байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь
гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрж, бүртгэлд тусгасан эсэх;

Аймгийн Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч
нар, харьяа байгууллагууд, Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газар болон гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг
хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл,
худалдан авах ажиллагаа, санхүүжилт болон хэрэгжилтэд
аудит хийж гүйцэтгэсэн.

АГУУЛГА

БҮЛЭГ 1

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 28.4 Хувийг
аймгийн 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэлд
үндэслэн төлөвлөөгүй байна.

БҮЛЭГ 2

Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион
байгуулах, түүний хэрэгжилтэд тавих захиалагчийн
хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл
арга хэмжээний 64 төсөл буюу 86.5 Хувь нь төлөвлөсөн
хугацаанд бүрэн хэрэгжсэн байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

БҮЛЭГ 1

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 28.4 ХУВИЙГ
АЙМГИЙН 2021-2025 ОНЫ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД
ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

Sh
Gan-Ulzi



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-аас 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 83 төсөл, арга хэмжээг 13,815.4 сая төгрөгийн төсөвт өртгөөр баталсан. Улмаар төсөвт тодотгол хийж, хөрөнгө оруулалтын жагсаалтыг өөрчлөн 74 төсөл, арга хэмжээг 9,125.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

Хүснэгт №1. 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөг


Ангилал	Тоо	Төсөв (сая төгрөг)
Барилга багууламж	15	2,678.30
Их засвар, тохижилт	16	2,531.40
Тоног төхөөрөмж, тавилга, автомашин	42	3,788.90
Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	1	127.00
Нийт	74	9,125.60

Эх сурвалж: Аудитын ажлын байримт

1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн боловч аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тулгуурлан төлөвлөөгүй байна.

Энэ хүрээнд 2025 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний бүтэц, хуваарилалтыг авч үзвэл, нийт төсөл, арга хэмжээний 14 хувийг боловсрол, 8 хувийг эрүүл мэнд, 9 хувийг соёл, 15 хувийг нутгийн өөрөө удирдах байгууллага, 15 хувийг тусгай чиг үүргийн байгууллага, 39 хувийг бусад салбарт тус тус хуваарилсан байна. Энэхүү хуваарилалтыг дараах графикаар харуулав.

Дүрслэл №1. Хөрөнгө оруулалтын төрөл



Эх сурвалж: Аудитын ажлын байримт



Дээрх төсөл, арга хэмжээг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан шалгахад 2,565.0 сая төгрөгийн өртөгтэй 21 төсөл, арга хэмжээ нь Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдаагүй байна. Энэ нь нийт төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 28.4 хувийг эзэлж байна.

Эдгээр төлөвлөлт нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.17, 6 дугаар зүйлийн 6.9, 6.10.3, 6.10.4 дахь заалтуудын шаардлагыг хангаагүй бөгөөд улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан төсөв, төлөвлөлтийг боловсруулах шаардлагуудтай нийцэхгүй байна.

Ийнхүү бодлогын баримт бичгүүдийн уялдаа хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, аймгийн хөгжлийн төлөвлөлтийн уялдаа алдагдах, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт хийгдэх эрсдэлийг бий болгож байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээнүүдийг олон нийтийн саналд үндэслэн эрэмбэлсэн эсэхийг хянахад:

- Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь хөрөнгө оруулалтын саналуудыг хүлээн авч байгаа ч нэгдсэн аргачлалаар үнэлж, эрэмбэлэхгүй байна.
- Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа иргэдийн бодит хэрэгцээ, хөгжлийн урт болон дунд хугацааны бодлоготой бүрэн уялдуулдаггүй, заримдаа өөрийн тойргийн сонирхолд илүү төвлөрөх хандлага ажиглагдаж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор¹ баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах журам”-ын 2.1.3, 2.2.1, 2.2.2 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

1. 4.1.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна:



Өмнөх аудитаар уг зөрчилтэй холбоотой зөвлөмж өгсөн боловч зөрчил давтан гарсаар байна.



Үүний улмаас хөрөнгө оруулалтын тэгш бус хуваарилалт үүсэж, зарим сум, багийн хөгжил орхигдох, мөн бодит хэрэгцээнд суурилсан төлөвлөлт алдагдах эрсдэл бий болж байна.



ДҮГНЭЛТ

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь бодит хэрэгцээ, шаардлагад суурилсан судалгаагүй, ач холбогдлоор нь эрэмбэлэн тодорхойлоогүй байх нь төсвийн үр ашгийг бууруулах, хязгаарлагдмал нөөцийг үр дүнгүй зарцуулагдах, тулгамдсан асуудлууд шийдвэрлэгдэхгүй хоцрох, иргэдийн төрд итгэх итгэл сулрах зэрэг сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй байна.

Иймд орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан, бодит судалгаанд суурилсан шалгуур, эрэмбийн дагуу төсөл, арга хэмжээг тодорхойлж, төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөх шаардлагатай байна. Мөн бага өртөгтэй, урсгал зардлын шинжтэй асуудлыг хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээс зайлсхийж, дунд хугацааны хөгжлийн бодлоготой бүрэн уялдуулахад онцгойлон анхаарах нь зүйтэй байна.

1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад төлөвлөлтийн шаардлага хангаагүй зарим төсөл, арга хэмжээг баталсан байна.

Нийт 3,300.7 сая төгрөгийн 18 төслөөс 2,627.7 сая төгрөгийн (79.6%) 14 төсөл зураг төсөвгүй батлагдсан бөгөөд үүнээс 2,331.7 сая төгрөгийн (70.6%) 9 төслийн зураг төслийг төсөв батлагдсаны дараа боловсруулж, 296.0 сая төгрөгийн (9.0%) 5 төслийн зураг төсөв огт боловсруулагдаагүй байна.

Хүснэгт №2. Төсөл, арга хэмжээний зураг төсвийн төлөвлөлтийн байдал

Ангилал	Тоо	Батлагдсан төсөв (сая төг)	Хувь
Нийт төсөл, арга хэмжээ	18	3,300.7	100%
Зураг төсөвгүй байхад жагсаалтад баталсан	14	2,627.7	79.6%
Үүнээс: батлагдсаны дараа зураг төсөв хийлгэсэн	9	2,331.7	70.6%
Үүнээс: огт хийгдээгүй үлдсэн	5	296.0	9.0%

Эх сурвалж: Аудитын ажлын байримт

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдээс ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 2,627.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан нь бодит хэрэгцээнд нийцээгүй хөрөнгө оруулалт хийгдэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хэрэгжүүлсэн төслүүдийн нийгэм, эдийн засгийн үр нөлөө сул байх зэрэг эрсдэл үүсгэж байна.

Цаашид хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж батлахдаа холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг чанд мөрдөж, бодит хэрэгцээ, судалгаа, үр ашгийн тооцоонд тулгуурлан шийдвэр гаргах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх замаар хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай байна.



Машин техник, тоног төхөөрөмжийн өртгийг зах зээлийн үнэ ханш, тээвэрлэлт, суурилуулалтын зардлыг харгалзан бодитоор төлөвлөсөн байна.



Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй 50.0 сая төгрөгийн зардлыг жагсаалтад тусгаж баталсан байна.

БҮЛЭГ 2

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН
БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН
ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.





Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 64 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс 12 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах гэрээний аргаар, 51 төсөл, арга хэмжээг харьцуулалтын арга болон нээлттэй тендер шалгаруулалтын журмаар тус тус зохион байгуулсан байна.

2.1 Худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.

Аймгийн ХАА-ны газар нь 4,126.0 сая төгрөгийн 27, сумын Засаг дарга нар 2,717.0 сая төгрөгийн 17, төсвийн шууд захирагч нар 543.4 сая төгрөгийн 7, нийт 51 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулжээ.

Хүснэгт №3. Хуулийн хугацаанд зохион байгуулаагүй ХАА-ны тоо

№	ХАА зохион байгуулсан байгууллага	Зохион байгуулсан ХАА-ны тоо	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хугацаанд зохион байгуулаагүй ХАА-ны тоо
1	Худалдан авах ажиллагааны газар	27	10
2	Сумд	17	6
3	Байгууллага	7	0
	Нийт	51	16

Эх сурвалж: Аудитын ажлын байримт

ХАА-г 2025.03.06-наас эхлүүлж, зарим төсөл, арга хэмжээнийхийг 2025.05.23 хүртэл оройтуулан төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд багтаан хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан байна.

Мөн ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан 27 төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг хуульд заасан хугацаанд шилжүүлээгүй, нэг төсөл, арга хэмжээг шийдвэрт тусгалгүй шилжүүлсэн нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4.1.1-д заалтыг зөрчсөн байна.

Түүнчлэн эрх шилжсэн зарим төсөл, арга хэмжээний үнэлгээний хороог хугацаа алдан байгуулж, хүсэлт ирүүлснээс 19-35 хоногийн дараа байгуулсан бөгөөд зарим захиалагч байгууллага худалдан авах ажиллагаа зохион байгуулах хүсэлтээ 6-110 хоногийн хоцрогдолтой хүргүүлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталснаас зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулах, баталгаажуулахад нэмэлт хугацаа зарцуулсантай холбоотой гэж үзэж байна. Улмаар худалдан авах ажиллагааг хугацаа алдан зохион байгуулснаар төсөл, арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах, он дамжин үргэлжлэх, өртөг нэмэгдэх зэрэг эрсдэл үүсжээ.

Иймд худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг эрт зохион байгуулж, төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг хуульд заасан хугацаанд шилжүүлэх, зураг төсөв, техникийн тодорхойлолт зэрэг шаардлагатай баримт бичгийг хугацаанд нь хүргүүлэх, үнэлгээний хороог тухай бүр байгуулан ажиллуулах талаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2.2 Тендерийн баримт бичиг боловсруулах болон худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд зөрчил илэрсэн.

Түүнчлэн тендерийн баримт бичиг боловсруулахдаа үнийн урьдчилсан судалгаа хийгээгүй, техникийн тодорхойлолт болон тавигдах шаардлагыг хангалтгүй боловсруулснаас ижил төрлийн барааг харилцан адилгүй үнээр худалдан авах, чанарын эрсдэл үүсэхээс гадна тендерт оролцогчдод ойлгомжгүй нөхцөл байдал бий болсон байна.

Мөн сумдад эрх шилжүүлсэн 7 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт оролцогчдод тавих шаардлагыг бүрэн тусгаагүй байна. Үүнд тусгай зөвшөөрлийн шаардлагыг тодорхой заагаагүй, техникийн тодорхойлолтыг тодорхой бус боловсруулсан, мөн санхүүгийн чадавх, техникийн боломж, туршлагын шалгуур үзүүлэлтийг орхигдуулсан нь тендерийг үнэлэхэд хүндрэл учруулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг алдагдуулах эрсдэл бий болгосон байна.



Мөн өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, үнэлгээний хороог тухай бүр байгуулаагүй, аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг хараат бус гишүүнээр томилон ажилдуулсан зөрчил давтан гарсан байна.



Ижил үзүүлэлт бүхий лед дэлгэцийн төсөвт өртгийг 60.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гэрээг 34.1-48.0 сая төгрөгөөр байгуулсан нь үнийн урьдчилсан судалгаа хангалтгүй хийгдсэнийг илтгэж байна.

Нийт худалдан авах ажиллагааны 31.3 хувийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1-д заасан хугацаанд зохион байгуулж дуусгаагүй.



Иймд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний онцлогт нийцүүлэн оролцогчдод тавих санхүү, техникийн болон туршлагын шаардлагыг тендерийн баримт бичигт тодорхой тусгах, техникийн тодорхойлолтыг үнийн урьдчилсан судалгаанд үндэслэн боловсруулах талаар аймаг, сумын Засаг дарга нар болон ХААГ-т албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.3 Мөн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг хянан үзэхэд үнэлгээний хороод тендерийн шаардлага хангаагүй оролцогчийг сонгон шалгаруулсан зөрчил илэрсэн байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хороод нийт 51 төсөл, арга хэмжээнээс 41 буюу 80.3 хувьд нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 26.4.2, 26.9, 27.5 дахь заалтуудыг зөрчсөн байна. Уг төслүүдийн нийт төсөвт өртөг 5,979.5 сая төгрөг байна.

Хүснэгт №4. Шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ХАА-ны тоо, хувь

	ХАА зохион байгуулсан байгууллага	Зохион байгуулсан ХАА-ны тоо	Шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ХАА-ны тоо	Хувь
1	Худалдан авах ажиллагааны газар	27	24	88.8
2	Сумд	17	13	76.4
3	Байгууллага	7	4	57.1
	Нийт	51	41	80.3

Эх сурвалж: Аудитын ажлын байримт

Дээрх зөрчлүүдийг ангилан үзэхэд нийт илэрсэн зөрчлийн 68.1 хувь нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 16, 17 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, техникийн чадавх болон туршлагын шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсантай холбоотой байна. Мөн зарим аж ахуйн нэгжийг тусгай зөвшөөрлийн шаардлага хангаагүй байхад шалгаруулсан зөрчил илэрчээ.

Хүснэгт №4. Шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ХАА-ны тоо, хувь

№	Хууль, журамд нийцээгүй үндэслэл	Төсөл, арга хэмжээний тоо /давхардсан/
1	Оролцогчийн ерөнхий шаардлагыг хангаагүй	2
2	Хуулийн 16 дугаар зүйл, ТББ-т тусгасан санхүүгийн чадавхын шаардлага хангаагүй	18
3	Хуулийн 17 дугаар зүйл, ТББ-т тусгасан техникийн чадавх, туршлагын шаардлага хангаагүй	27
4	Тендерийн баримт бичигт шаардсан тусгай зөвшөөрөлгүй	5
5	Төсөв, нийлүүлэлтийн хуваарь, тоо хэмжээ зөрүүтэй	11
6	ТББ-т шаардаагүй шалгуураар үнэлсэн	3
	ДҮН	66

Эх сурвалж: Аудитын ажлын байримт

Түүнчлэн үнэлгээний хороод тендерийг үнэлэхдээ хууль, журам, аргачлалыг бүрэн мөрдөөгүй, тендерийн баримт бичигт тусгагдаагүй шалгуураар үнэлгээ хийсэн, хурлын тэмдэглэлийг бүрэн хөтлөөгүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн байна. Эдгээр зөрчил нь тендерийн үнэлгээний үйл ажиллагаанд хууль, журам мөрдөх байдал хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд тендерийн үнэлгээг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, оролцогчдын санхүүгийн болон техникийн чадавх, туршлагыг бодитой үнэлэх, үнэлгээний хорооны үйл ажиллагааг холбогдох журамд нийцүүлэн хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудад албан шаардлага, зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.4 Худалдан авах ажиллагаанд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой худалдан авах ажиллагааны хүрээнд захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрч 11 гомдол гаргаснаас Сангийн яам 8 тохиолдолд захиалагчийн шийдвэрийг үндэслэлтэй гэж үзэн шийдвэрлэсэн байна.



Нийт 51 төсөл, арга хэмжээнээс 41-д нь тендерийн шаардлага хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна.



Аймгийн ИТХ-ын ажлын албаны өрөөнүүдийг засварлах ажилд шалгарсан “Азмөнх жаргал” ХХК нь тендер нээх өдөр нийгмийн даатгалын шимтгэлд 982.1 мянган төгрөгийн өртэй байсан байна.



Түдэвтэй сумын нийтийн спортын талбай байгуулах ажилд шалгарсан “И эс би ай” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байхад шаардлага хангасан гэж үнэлсэн байна.



Хүснэгт №4. Шаардлага хангаагүй гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан ХАА-ны тоо, хувь

№	ХАА зохион байгуулсан байгууллага	Гарсан гомдлын тоо	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй шийдвэрийн тоо
1	Худалдан авах ажиллагааны газар	9	8
2	Сумд	1	0
3	Байгууллага	1	0
	Нийт	11	8

Эх сурвалж: Аудитын ажлын байримт

Худалдан авах ажиллагаатай холбоотой гаргасан 11 гомдлоос 3-ыг Сангийн яам үндэслэлтэй гэж үзэн захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хянан үнэлэх чиглэл өгсөн байна. Гэвч зарим үнэлгээний хороо Сангийн яамны шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүйгээс шаардлага хангаагүй оролцогчийг дахин шалгаруулсан болон захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчил илэрчээ.

Эдгээр зөрчил давтан гарахад худалдан авах ажиллагааны хууль, журам, аргачлалыг мөрдөх байдал хангалтгүй, үнэлгээний хорооны гишүүдийн мэдлэг, арга зүйн чадавх дутмаг, мөн гаргасан шийдвэрт тавих захиалагчийн хяналт сул байгаа нь нөлөөлсөн байна.

Иймд үнэлгээний хорооны гишүүд болон худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагчдад арга зүйн зөвлөгөө, сургалт зохион байгуулах, үнэлгээний хорооны шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах талаар аймгийн ЗДТГ болон Худалдан авах ажиллагааны газарт албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Өмнөх аудитаар аймгийн Засаг дарга болон Худалдан авах ажиллагааны газарт өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна. Давтан шалгалтаар тендерийн үнэлгээ хийхдээ хууль, журам болон тендерийн баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй оролцогчийг шалгаруулсан, тендер сонгон шалгаруулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил давтан гарсан нь өмнөх аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүйг харуулж байна.

Иймд өмнөх аудитын шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Түүнчлэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байгаа тул аймгийн хэмжээнд нэгдсэн удирдамжаар дотоод аудит зохион байгуулж, хяналт хариуцлагыг сайжруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

ДҮГНЭЛТ



Их-Уул сумын Соёлын төвд тоног төхөөрөмж, лед дэлгэц худалдан авах тендерт Сангийн яам захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгож дахин үнэлэхийг даалгасан боловч үнэлгээний хороо дахин үнэлэхдээ шаардлага хангаагүй аж ахуйн нэгжийг дахин шалгаруулсан байна.

БҮЛЭГ 3

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ 64 ТӨСӨЛ БҮЮУ 86.5 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН
ХУГАЦААНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН БАЙНА.






3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт 86.5 хувьтай байна.

Завхан аймаг дахь Төрийн аудитын газраас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар нийт 74 төсөл, арга хэмжээнээс 64 нь буюу 86.5 хувь нь төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.

Дүрслэл №2. Захиалагч болон зохиогчийн хяналт хийсэн судалгаа



Эх сурвалж: Аудитын ажлын байримт

Гэсэн хэдий ч 8 төсөл, арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжээгүй бөгөөд 809.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон ч ажлыг хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй байна. Үүнд зам, инженерийн шугам сүлжээ, иргэдийн хөгжлийн төв, спортын талбай, халуун усны төв зэрэг төсөл, арга хэмжээнүүд багтаж байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан нь санхүүжилтийн хуваарилалт он дамжсан, шийдвэр гаргалт удааширсан, гүйцэтгэлийн чанар хангалтгүй байсантай холбоотой бөгөөд гэрээний хугацаа сунгагдаж, зарим ажил 2026 он руу шилжсэн байна. Энэ нь төсвийн хөрөнгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулах эрсдэл үүсгэж байна.

Иймд хугацаандаа хэрэгжээгүй 8 төсөл, арга хэмжээтэй холбоотой зөрчлийг арилгаж, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах талаар холбогдох байгууллагуудад албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн хэрэгжээгүй 2 төсөл, арга хэмжээ байна. Арц суурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих ажлын тендерийг 4 удаа зарласан боловч шаардлага хангасан оролцогч ирүүлээгүйгээс төсөл дараа он руу шилжсэн байна. Харин Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийн засварын ажилд гүйцэтгэгч шалгарсан боловч ажлаа хугацаанд нь эхлүүлээгүйгээс төсөл хэрэгжээгүй байна.

Иймд хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг арилгаж, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аудитаар зарим төсөлд санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс давуулан олгосон зөрчил илэрсэн байна. Тухайлбал, Алдархаан сумын Иргэдийн хөгжлийн төвийн ажлын бодит гүйцэтгэл 40 хувьтай байхад 70 хувийн гүйцэтгэлээр тооцон санхүүжилт олгосон.



Түдэвтэй сумын спортын талбайн ажил бүрэн хэрэгжээгүй байхад 200 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.



Түүнчлэн орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаанд 1.1 тэрбум төгрөг, данс хоорондын шилжүүлгээр 279.9 сая төгрөгийг зарцуулсан нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан нөхцөл байдал үүсгэжээ.



Хэрэгжээгүй 2 төсөл, арга хэмжээ байна. Үүнд Арц суурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих болон Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийн засварын ажил багтаж байна.



Техникийн хяналтын зардлын зарцуулалтад 335.8 сая төгрөгийн зориулалтын бус болон баримтын бүрдүүлэлт дутуу зарцуулалт илэрсэн байна.



Мөн зарим техник, тоног төхөөрөмжийг гэрээ, техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй байхад хүлээн авсан зөрчил илэрсэн байна. Тухайлбал: Хүүхэд хамгааллын үйлчилгээний автомашин болон газар тариалангийн усалгааны системийн тоног төхөөрөмжүүд техникийн үзүүлэлт дутуу байсан ч ашиглалтад хүлээн авчээ.

Зураг №1. Техникийн шаардлага хангаагүй тоног төхөөрөмж хүлээн авсан жишээ



ДҮГНЭЛТ

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон 3.6 Тэрбум төгрөгийн хөрөнгийг санхүүгийн бүртгэлд бүрэн тусгаагүй зөрчил мөн илэрсэн байна. Энэ нь хөрөнгө эзэнгүйдэх, бүртгэл тайлагналын үнэн зөв байдал алдагдах эрсдэлийг бий болгож байгааг аудитын байгууллага онцоллоо.

Нийт аудитын үр дүнд 14.0 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 7.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 13.3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 770.8 сая төгрөгийн дүнтэй зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, бүртгэлийг сайжруулж, төсвийн хөрөнгийн үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих 74 төсөл, арга хэмжээний 86.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 10.8 хувь нь гүйцэтгэл дутуу, 2.7 хувь нь хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй төслүүдэд Арцсуурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих болон Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийн засварын ажил хамаарч байна.
2. Аймгийн ИТХ-аас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлахдаа төлөвлөлтийн шаардлага хангаагүй зарим төсөл, арга хэмжээг тусгасан нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үр нөлөө, оновчтой байдлыг бууруулсан байна.
3. Аймгийн ИТХ нь Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн барьсан төсвийг батлахдаа техник, эдийн засгийн үндэслэл хийгээгүй, зураг төсөвгүй, хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг оруулан баталсан байна.
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тусдаа төсөвтэй байгууллагуудын хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж, түүний зорилго, мөн чанарыг алдагдуулж байна.
5. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт хангалтгүй байснаас нийт худалдан авах ажиллагааны 31.3 хувийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулж дуусгаагүй байна.
6. Үнэлгээний хороод тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй 41 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.
7. Үнэлгээний хорооны гишүүд, сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагч нарт тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийг хянан үзэх, үнэлэх зэрэг мэргэжил арга, зүйн зөвлөгөөгөөр хангаж, үүрэг хариуцлагыг идэвхжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.
8. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, худалдан авах ажиллагаатай холбоотой гомдлын шийдвэрийн мөрөөр тавих хяналт болон хариуцлагын тогтолцоо сул байна.
9. Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд нэгдсэн удирдамжаар дотоод аудит хийж хяналт хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авах зайлшгүй шаардлага үүссэн байна.
10. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн гэрээг бүрэн дүгнэж баталгаажуулаагүй байна.
11. Сумдад хэрэгжиж буй барилга байгууламж, их засварын ажлуудад Барилгын тухай хуульд заасны дагуу захиалагчийн болон зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хэрэгжүүлээгүй, мөн ажлын бодит гүйцэтгэлд үндэслэлгүйгээр санхүүжилтийг илүү олгосон байна.
12. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарим ажлыг техникийн тодорхойлолтод нийцүүлэн хүлээн аваагүй байна.
13. Их засвар, барилга байгууламжийн ажлын хүрээнд зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хэрэгжүүлэх, тухайлбал хяналтын төсөв боловсруулсан байгууллагатай зохиогчийн хяналтын гэрээг заавал байгуулж, хяналт тавиулах шаардлагатай байна.
14. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хууль тогтоомжийн дагуу захиалагчийн хяналт хэрэгжиж байгаа боловч гүйцэтгэгчийн гаргасан зөрчил, дутагдалд хариуцлага тооцох ажиллагаа хангалтгүй байгаагаас гэрээний хугацаа хэтрэх, улмаар төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.
15. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.
16. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж бүрэн ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээ нь хүүхдийн сурч, боловсрох болон иргэдийн ажиллаж, амьдрах орчинд эерэг нөлөө үзүүлж байна.
17. Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт 78.3 хувьтай байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахдаа төсөвлөлтийн шаардлага хангасан арга хэмжээг баталж байх;
2. Эрдэнэхайрхан суманд илүүдэлтэй байгаа 6 ширхэг цамхагт гэрэлтүүлгийг бодит хэрэгцээ, ачаалал, хүн амын нягтаршил, гэрэлтүүлгийн хүртээмжид нийцүүлэн нэн шаардлагатай бусад сум, суурин газарт холбогдоххууль, журмын дагуу шилжүүлэн ашиглахын зэрэгцээ цаашид орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хэрэгцээний судалгаа, техник-эдийн засгийн үндэслэл, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бодитой, үндэслэлтэйгээр тооцож, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үр ашгийг дээшлүүлэх, мөн шийдвэр гаргах түвшинд давхардал, илүүдэл үүсэх эрсдэлийг урьдчилан тооцож байх;
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд нэгдсэн удирдамжаар дотоод аудит хийж хяналт хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авч үр дүнг тайлагнах;
4. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж аймгийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, холбогдох журмын хүрээнд яаралтай зохион байгуулж, төлөвлөгөөт хугацаанд нь багтаан бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байх;
5. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэл, баримт бичгийн бүрдэл, холбогдох албан тушаалтнуудын хяналт, баталгаажуулалтыг бүрэн хангуулсны үндсэн дээр олгож байх;
6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, данс хооронд гүйлгэн зарцуулахгүй байх;
7. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хүлээн авахдаа техникийн тодорхойлолт, зураг төсөв, холбогдох стандартын шаардлагыг бүрэн хангуулж байх, шаардлага хангаагүй ажлыг хүлээн авахгүй байх.

СУМЫН ЗАСАГ ДАРГА НАР-Т

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах санхүү, техникийн болон туршлагын шаардлагыг тодорхой тусгаж байх;
2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төлөвлөгөөнд тусгасан цаг хугацааг мөрдөн ажиллах, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;
3. Үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулах болон тендерийг хянаж, үнэлэхдээ бүх гишүүдийн оролцоог хангах, үнэлгээг маягтын дагуу хийх, хурлын тэмдэглэлийг журмын дагуу бүрэн гүйцэд үнэн зөв хөтлөх

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР-Т

1. Түншлэл, туслан гүйцэтгэгчийн мэдээллийг дүгнэлт, зөвлөмж, гэрээнд бүрэн тусгаж байх.

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР-Т

1. Сумдад хэрэгжүүлж байгаа барилга байгууламж, их засварын ажлын мэдээллийн самбарыг стандартын шаардлагын дагуу бүрэн хийж байршуулах, Барилгын тухай хуульд заасны дагуу захиалагчийн болон зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хэрэгжүүлэн, захиалагч болон хяналт хэрэгжүүлэгч байгууллагын хяналт, хариуцлагыг сайжруулж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу гаргаж, мөн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

2026 он